

ЦАГААН-ОВОО СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН

“МОНГОЛ ХЭЛНИЙ” АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

2024он (8 анги)

60минут

Сурагчийн нэр:

Нийт: 30 оноо

А хувилбар

Монгол кенгуру

Уутгүй л болохоос биш Австралийн кенгуру манай алаг даага хоёрт ялгаа бараг байхгүй. Кенгурог 1000 дахин багасгаад тавьчхаа юу гэлтэй адилхан. Урд хөл гээд байх юмгүй, хойд хоёр хөл нь урт. Иймд хойд хөлөөрөө дэгдэн шувуу нисэх мэт хурдална. Ховордсон амьтдын тоонд бичигдсэн алаг даага Монгол, Хятад, Казахстан, Кыргызстан зэрэг Азийн цөөн оронд бий. Мөн Африк тивийн хойд хэсэгт тэдний төрөл төрөгсөд цөөнгүй. Хамгийн анх 1970-1980 оны хооронд ОХУ-ын эрдэмтэн Г.Шенброт Монголын говь нутаг дахь алга даага, түүний төрөл зүйлүүдийг судалжээ.

Алаг даага хээр талд нүхэнд зурам шиг амьдардаг байна. Гэхдээ гаргүй амьтан нүх ухах гэж юу байхав. Бусдын хаясан голсон юманд л толгой хоргоддог ажээ. Зуны эхээр төрж, 3-6 зулзага гарган, хөхөөрөө өсгөнө. Тэднийгээ өлсгөчихгүйн тулд үдшийн бүрийгээс үүрийн гэгээ тустал ургамлын иш, навч, юу л олдсоныг нь идэж өөртөө сүү оруулна. Шавж хүртэл иддэг гэсэн. Уг нь өдөр нүхнээсээ гардаггүй зантай. Гэвч зулзага өлсөөд байвал идэш тэжээл олохын тулд явахаас аргагүй. Бие жижиг, хүүхэд олон, сүү бага. Амьдралын ийм гачигдлаас болж, хөөрхий эх хулгай хийхэд хүрдэг гэнэ.

Тэрээр том хөхтөн амьтдын болон малын сүүг шөнө нууцаар хөхөж хулгайлдаг. Сонин байгаа биз. Ялангуяа үнээ, ямааг бүр гаргуун хөхнө. Ямаа уг нь адтай мал даа. Гэвч ямааг хотондоо хэвтэж байхад сэрээхгүйгээр дэлэнг нь шолбойтол сорчихдог. *Хивэхээ болихоор нь хөхөхөө больчихоод, хивэхээр нь сороод л ... ямаа ишгээ хөхүүлж байна гэж зүүдлээд л *ивлээд байна. Алаг даага амьтныг ийнхүү илбэддэг чадвартай. Тэр амаараа гулгитал хөхөж аваад үүрийн тэнгэр доор нохой шуугиулан одно. Ямаа хүртэл хууртаж байхад үхэр тэнэг бол бүр ойлгомжтой. Үрээ өсгөх гэж ийнхүү үйлээ үзэх бөлгөө.

Зулзагууд нь өвөл цуг ичээд хавар тарна. Том болсон тэднийгээ эх нь нэг их тоохгүй. Ер нь хүнээс бусад амьтан хөгширсөн хойноо хөлөө хучуулах гэж үр хүүхэд гаргадаггүй. Энэ нь ч бараг шулуун. **Гэхдээ** алаг дааганы үрст нэг гомдууштай явдал бий. Юу вэ гэвэл, эхийгээ ичээндээ унтаж байхад нь түрүүлж сэрээд унтаагаар нь хаяад явчихдаг гэнэ. Мөн ч хуншгүй еэ. Эх ч бас цагтаа тэгж байсан байлгүй.

Ж.Мягмарсүрэн “Долоо дахь хөхний гавар”

**хивэх - мал, амьтан идсэн өвсөө дахин дахин зажлах*

1. Эхийн эхлэл хэсэг алаг дааганы ерөнхий шинж болоод тархцын тухай бичсэн бол гурав дахь цогцолборт юуг тайлбарласан бэ? [2 оноо]

.....

2. Дээрх эхийн түлхүүр үгсийг тоочин бичнэ үү?[2 оноо]

.....

3. Сүүлийн цогцолборын “Гэхдээ” холбох үгийг ямар утгаар хэрэглэсэн бэ? Жишээгээр тайлбарлаарай.[2 оноо]

.....

4. Дараах үгийг үг зүйн бүрэн задлал хийж, тайлбарлаарай.[4 оноо]

Малчдынхаасаа

5. Нэрийн ба үйлийн холбох нөхцөлөөр холбогдсон, найрсан угсраа үг тус бүр 2 жишээ бичнэ үү? [2 оноо]


Нэрийн

Үйлийн

6. Дараах өгүүлбэрийг өгүүлбэрийн гүшүүдээр зурж, 3-н бүрэлдэхүүнт цөм бүтцийг олоорой. [3 оноо]

Балдан өглөөний нарнаар гэрээс гарч, Туяагийн хар машиныг асаан авчирлаа.

7. Үндэсний бичгийн кирил бичигт хөрвүүлээрэй.[5 оноо]



8. Дараах зохиолуудыг зохиолчтой нь зөв харгалзуулаарай.[5 оноо]

- | | |
|--------------------------|-----------------|
| a. “Хүмүүн бичиг” шүлэг | 1. Б. Ренчин |
| b. “Тэхийн зогсоол” | 2. Ж. Барамсай |
| c. “Монгол хэл” | 3. Д. Намдаг |
| d. “Цүнхтэй инээд” | 4. Б. Явуухулан |
| e. “Үрэгдсэнийг хүлээгч” | 5. С. Дулам |

9. Дараах тохиолдлыг уншаад, бүтцийн дагуу “Өргөдөл” бичээрэй. (5 оноо)

Нийгмийн ажилтанд – Анги хамт олноороо санаачлан, “Хоггүй сургууль” аян өрнүүлэх тухай өргөдөл бичих.

Өргөлөө бичихдээ төлөвлөгөөний дагуу А4 цаасан дээр гараар бичнэ. Дараах шалгуурыг баримтлаарай.

- ✓ Өргөдөл бичихдээ стандарт хэмжээний дагуу зайгаа тохируулах
- ✓ Эхлэл, гол, төгсгөл хэсгээ ялган догол мөр гарган бичих
- ✓ Өргөдөл гаргах болсон шалтгаан болон шийдүүлэх гэж байгаа хүсэлтээ тодорхой бичих
- ✓ Өөрийн овог, нэр, хаяг, утсаа бичих
- ✓ Өргөдөл гаргасан он, сар, өдөр
- ✓ Зөв бичих дүрмийн болон найруулгын алдаагүй, гаргацтай бичих

БАТЛАВ

СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ

Б. ТӨМӨРЧӨДӨР

ЦАГААН-ОВОО СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН

“МОНГОЛ ХЭЛНИЙ” АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

2024он (8 анги)

60минут

Сурагчийн нэр:

Нийт: 30 оноо

В хувилбар

Шилүүс нүүрээ угаах дуртай

Шилүүс бол муурын төрөл. Шилүүсний бие 73-106 см, сүүл 10-24 см, чих 7.5-9.9 см урттай. Хамгийн онцлог нь чихнийхээ үзүүрт 4-7 см урт шовх хар өнгийн цацаг үстэй, чих нь босоо тул соотон харагдана. Мөн тавхай том, мөч урт, бор саарлаас шаргалдуу зүстэй.

Эднийхэн ариун цэвэрч зангаараа бусдаас ялгардаг. Өдөр нь хад асган доогуур бүгээд унтчихна. Оройн сэрүүн ормогц босоод хамгийн түрүүнд нүүр гараа угаана даа. Чулуун дээр сууж, хоёр тавхайгаа шүлдсэж байгаад л хошуу, хамар, нүд, чихний араа нойтон тавхайгаараа нямбай гэгч нь угаана. Урт үстэй чихээ хугартал үрчиж зүлгэдэг ба зулзагаа хүртэл яг ингэж цэвэрлэнэ. Ийм цэвэрч амьтан бас байдаг аа.

Нүүр гараа угааж цэвэрлэснийхээ дараа тэд анд гарна. Мөр мөр дээрээ гишгэж, цувж явдаг тул цасан дээгүүр долоон шилүүс явжээ гэхэд ердөө л ганц амьтан явж өнгөрсөн мэт мөр үлдсэн байдаг байна. “Босс” нь хамгийн түрүүнд, бусад нь араас нь цэрэг мэт даган шогшино. Идшилж байгаа бор гөрөөс рүү газарт наалдан мяраана. Ямар ч дуу чимээ гаргахгүй, газраар хөглөрөх хатсан навчийг ч шажигнуулалгүй мөлхөж чаддаг аж. Ингээд “босс” гэнэт дайрч гөрөөсний хүзүүнд дөрвөн соёогоо зоож, дарж унагана. Түүний ам, завж бувалзан хөдлөөд л байна, хөдлөөд л байна. Цусыг нь сорж буй нь тэр. Цасан дээр ганц дусал цус ч дусаалгүй цэвэрхэн сорно гээч. Бусад нь махыг хувааж идэх бөгөөд хооллосныхоо дараа бас л хошуу амаа долоож цэвэрлэнэ.

Тэд долоо наймаараа нэг удирдлага дор *отоглож амьдардаг. Энэ нь ядруу дорой нь чадалтай чадвартайнхаа нөмөр нөөлөгт явах амьдралын бас нэг зохилдлого юм. **Гэхдээ** толгойлогчоосоо болж отгоороо намнуулах* нь ч бас бий. Анчдын нохдод хөөгдсөн долоон шилүүс модонд авирчээ. Модны оройд толгойлогч, бусад нь доошоо мөчир мөчир дээр эрэмбээрээ сууцгаан *боорлон хуцах нохдыг төвөгшөөсөн маягтай харж байв. Анчид тэднийг доороос эхлэн намнажээ. “Босс” биш нэг муу “чур” үсэрч ойчиход бусад нь огт үл тооно. Ингэсээр хамгийн сүүлд “босс”-ыг намнав. Хэрэв эхлээд толгойлогчийг *намнасан бол яах байсан бэ гэж үү? Доошоо унаж буй толгойлогчоо хараад бусад нь “Босс тулалдахаар ухасхийлээ” гэж эндүүрч бүгд харайлдан бууж анчдын өөдөөс дайрах байв. Нэгийгээ хэт тахин шүтэх нь ийм хортой аж.

Ж.Мягмарсүрэн “Долоо дахь хөхний гавар”

1. Эхийн эхлэл хэсэг шилүүсний ерөнхий шинж болоод төрлийн тухай бичсэн бол 3 дахь цогцолборт юуг тайлбарласан байна вэ? [2 оноо]

.....

2. Дээрх эхийн түлхүүр үгсийг тоочин бичнэ үү? [2 оноо]

.....

3. Сүүлийн цогцолборын “Гэхдээ” холбох үгийг ямар утгаар хэрэглэсэн бэ? Жишээгээр тайлбарлаарай. [2 оноо]

.....

4. Дараах үгийг үг зүйн бүрэн задлал хийж, тайлбарлаарай. [4 оноо]

Нөхдийнхөөсөө

5. Нэрийн ба үйлийн холбох нөхцөлөөр холбогдсон, найрсан угсраа үг тус бүр 2 жишээ бичнэ үү? [2 оноо]


Нэрийн

Үйлийн

6. Дараах өгүүлбэрийг өгүүлбэрийн гүшүүдээр зурж, 3-н бүрэлдэхүүнт цөм бүтцийг олоорой. [3 оноо]

Саруул өчигдөр сургуулиас олсон, Болдын улаан номыг сонирхон уншлаа.

7. Үндэсний бичгийн кирил бичигт хөрвүүлээрэй. [5 оноо]



8. Дараах зохиолуудыг зохиолчтой нь зөв харгалзуулаарай. [5 оноо]

- | | |
|--------------------------|-----------------|
| a. “Монгол хэл” шүлэг | 1. Ж. Барамсай |
| b. “Тэхийн зогсоол” | 2. Б. Ренчин |
| c. “Хүмүүн бичиг” | 3. Д. Намдаг |
| d. “Үрэгдсэнийг хүлээгч” | 4. Б. Явуухулан |
| e. “Цүнхтэй инээд” | 5. С. Дулам |

9. Дараах тохиолдлыг уншаад, бүтцийн дагуу “**Өргөдөл**” бичээрэй. (5 оноо)

Нийгмийн ажилтанд – Анги хамт олноороо санаачлан, “Хоггүй сургууль” аян өрнүүлэх тухай өргөдөл бичих.

Өргөлөө бичихдээ төлөвлөгөөний дагуу А4 цаасан дээр гараар бичнэ. Дараах шалгуурыг баримтлаарай.

- ✓ Өргөдөл бичихдээ стандарт хэмжээний дагуу зайгаа тохируулах
- ✓ Эхлэл, гол, төгсгөл хэсгээ ялган догол мөр гарган бичих
- ✓ Өргөдөл гаргах болсон шалтгаан болон шийдүүлэх гэж байгаа хүсэлтээ тодорхой бичих
- ✓ Өөрийн овог, нэр, хаяг, утсаа бичих
- ✓ Өргөдөл гаргасан он, сар, өдөр
- ✓ Зөв бичих дүрмийн болон найруулгын алдаагүй, гаргацтай бичих